**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 09 сарын 20 өдөр Дугаар А/94 Улаанбаатар хот

Менингококкт халдварын эсрэг
вакцинаар дархлаажуулах тухай

Дархлаажуулалтын тухай хуулийн гуравдугаар бүлгийн 11.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын “Нөхөн, нэмэлт, тархвар судлалын заалтаар дархлаажуулалт хийх журмын тухай” 34 тоотын нэгдүгээр хавсралтын гуравдугаар заалт, ХӨСҮТ-ийн 2018 оны А/84 тоот тушаалыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Менингококкт халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах ажлын хэсгийг нэгдүгээр, вакцин, дагалдах хэрэгслийн хуваарийг хоёрдугаар, мэдээлэх хүснэгтийг гуравдугаар хавсралтаар тус тус батлсугай.
2. Дүүргийн хэмжээнд 2-7 насны хүүхдүүдийг Менингококкт халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах ажлыг зохион байгуулахыг НЭМТҮЭО дарга /Б.Лувсанням/-д даалгасугай .
3. Харъяа нутаг дэвсгэрийн эрсдэлт бүлгийн 2-7 настай хүүхдүүдийг Менингококкт халдварын эсрэг вакцинаар 09-р сарын 18-28-ны хооронд дархлаажуулах ажлыг зохион байгуулан, мэдээг өдөр тутам Дүүргийн эрүүл мэндийн төвд мэдээлж байхыг Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт үүрэг болгосугай
4. Менингококкт халдварын эсрэг вакцинаар дархлаажуулалтын явцад хяналт тавьж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.
5. Менингококкт халдварын эсрэг вакцины хамралтын мэдээг өдөр бүр батлагдсан хүснэгтийн дагуу нэгтгэж ХӨСҮТ, НЭМГ-т мэдээлэхийг дархлаажуулалт хариуцсан тархвар судлаач /Н.Ганчимэг/-т үүрэг болгосугай
6. Энэ тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ЭТҮЧАлбаны дарга /Б.Оюумаа/-д даалгасугай.

ДАРГА Э.БОДЬЦЭЦЭГ

8 170 70 0781

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн
2018 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн
А/94 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| | |
|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | НЭМТҮЭО дарга Б.Лувсанням |
| Нарийн бичиг: | Тархвар судлаач Н.Ганчимэг |
| Гишүүд: | Өрхийн менежер Г.Даваасүрэн |
| | ХӨТСА-ны дарга С.Өлзийжаргал |
| | Тархвар судлаач Ө.Ариунжаргал |
| | ӨЭМТ-ийн дарга нар |

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн
2018 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн
А/94 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

# МЕНИНГОКОККТ ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИН,ДАГАЛДАХ ХЭРЭГСЛИЙН ХУВААРЬ

| № | ӨЭМТ-ийн нэр | Вакцин хүн тун | 5г тариур | 0,5г тариур |
|---|---|---|---|---|
| 1 | Мөнхбадрах | 80 | 8 | 80 |
| 2 | Тэрмэстий | 110 | 11 | 110 |
| 3 | Энхтитэм | 170 | 17 | 170 |
| 4 | Цэц-до | 120 | 12 | 120 |
| 5 | Манал үйлст | 50 | 5 | 50 |
| 6 | Чанд авиа | 90 | 9 | 90 |
| 7 | Хашчагнуур | 50 | 5 | 50 |
| 8 | Уясах | 80 | 8 | 80 |
| 9 | Аяут | 90 | 9 | 90 |
| 10 | Аминтус | 100 | 10 | 100 |
| 11 | Амгалан-өрх | 150 | 15 | 150 |
| 12 | Био асралт | 50 | 5 | 50 |
| 13 | Туул тосгон | 40 | 4 | 40 |
| 14 | Энх Амгалан өлзийт | 50 | 5 | 50 |
| 15 | Мэндсаруул өрх | 200 | 20 | 200 |
| 16 | Энхбуянтманал | 70 | 7 | 70 |
| **Нийт** | | **1500** | **150** | **1500** |

Хуваарь гаргасан:

Тархвар судлаач Н.Ганчимэг

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн
2018 оны 09 дүгээр сарын 21-ны өдрийн
А/44 тоот тушаалын гуравдугаар хавсралт

**Менингококкт халдварын эсрэг вакцины мэдээлэх хүснэгт**

| № | Байгууллагын нэр | Авсан вакцины тоо | Устгасан | Насны бүлэг | | | | | | ДДУХ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | |
| 1 | | | | | | | | | | |
| 2 | | | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | | |
| 4 | | | | | | | | | | |
| 5 | | | | | | | | | | |